

Сангийн сайдын 2013 оны 05
дугаар сарын 31-ний өдрийн
125 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

**(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)**

2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт орсон.
**ХУУЛЬ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
БОДЛОГЫН ГАЗАР**

Улаанбаатар
2013 он

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах бараа буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: www.e-procurement.mn

**[ДОТУУР БАЙРНЫ ХҮҮХДИЙН ХОЛНЫ БҮТЭЭГДЭХҮҮН] НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: ДОТУУР БАЙРНЫ ХҮҮХДИЙН ХОЛНЫ
БҮТЭЭГДЭХҮҮН

Төслийн дугаар: УВАЗАСЗДТГ-202001012

Харьцуулалт/
гэрээний дугаар:

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

ОГНОО : 2020.02.28

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР, ДУГААР : “Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны бүтээгдэхүүн нийлүүлэх” тендер, УВАЗАСЗДТГ-202001013

[Завхан сумын Сургууль] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **дотуур байрны хүүхдийн хоолны бүтээгдэхүүн]**–ийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн материалыг WWW.TENDER.GOV.MN цахим хаягт нэвтэрч, эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** (тавин мянган) төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийг **[2020 оны 3-р сарын 30-ны 14.00 цаг]-аас өмнө** WWW.TENDER.GOV.MN цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 3-р сарын 30]-ны өдрийн [15.00]¹-т** ИТХ-ын нарийн бичгийн даргын өрөөнд нээнэ.

Дотоодны давуу эрх тооцохгүй.

Тендерийн баталгаа шаардахгүй.

Тендерийн төсөвт өртөг- 45.582.100 төгрөг

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[ЗДТГ, Д.Батдэлгэр \89338977\, С.Энхцацрал \86988814\, Н.Эрдэнэцэцэг \88301064\]

ЗАВХАН СУМЫН ЗДТГ

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [2] жилийн санхүүгийн тайлан</p> <p>Сүүлийн [2 жил] туршлагын мэдээлэл</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: [хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулах тусгай зөвшөөрөл, ААН-ийн гэрчилгээний хуулбар,</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: [ЗДТГ ИТХ-ын НБДаргын өрөө]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: [1 давхар] [Энэ нь тендер хоцрох, эсвэл буруу газарт хүргэгдэхээс сэргийлэхэд чухал ач холбогдолтой]</p> <p>Огноо: [2020 оны 3 дугаар сарын 30-ний өдөр]</p> <p>Цаг: [14 цаг 00 минут]</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: [ЗДТГ ИТХ-ын нарийн бичгийн даргын өрөө]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 1 давхар</p> <p>Огноо: [2020 оны 3 дугаар сарын 30-ны өдөр]</p> <p>Цаг: [15 цаг 00 минут]</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. ААНБ-ын гэрчилгээ 2. Тусгай зөвшөөрөл 3. Мэргэжлийн ажилтан худалдагчийн үнэмлэхийн хуулбар
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: [УВАЗАСЗДТГ-202001012]</p>

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. **Барааны тодорхойлолт:** [Дотуур байрны хүүхдийн хоолны бүтээгдэхүүн нийлүүлэх тендер
2. **Стандарт:** *Монгол, Орос, Хятад улсын стандартад нийцсэн байх*
3. **Баглаа, боодол:** [хайрцаг, сав, уут нь бүрэн бүтэн, лац ломботой, хадгалалтын горим зөрчөөгүй, хугацаа дуусаагүй байх]
4. **Бараа хүргэх газар:** [Завхан сумын Сургуулийн гал тогоо]
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
					<i>2020 оны 4-р сарын 6</i>	<i>2020 оны 12.31</i>	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

ДОТУУР БАЙРНЫ ХҮҮХДИЙН ХООЛНЫ ТЕНДЕРИЙН
ҮНИЙН САНАЛ

2020

Сургууль

№	Материалын нэр	Бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт	Хэмжих нэгж	Тоо/ш	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Мах/хонь/	Мал эмнэлгийн бичиг,тамга тэмдэг даруулсан 14-с дээш кг стандартын дагуу бэлтгэсэн	кг	2500		
2	Мах /үхэр/	Мал эмнэлгийн бичиг,тамга тэмдэг даруулсан,цэвэр жингээр жижиглэн бэлтгэсэн	кг	2500		
3	Гурил	Улаанбуудайн 50кг-тай 1-р зэрэг	кг	400		
4	Цагаанбуддаа	Орос,хятад гарал үүслийн бичигтэй, хадгалалт сайн	кг	600		
5	Гоймон	Шар цаастай,алтан тариа	ш	400		
6	Гоймон	Уурагжуулсан,хугацаатай	ш	500		
7	Масло	Орос,хугацаатай,хадгалалт сайн	кг	50		
9	Элсэн сахар	Орос савалгаа сайтай,хугацаатай,хадгалалт сайн	кг	80		
10	Еэвэн	Увс хүнс,сүвд,хугацаатай,хадгалалт сайн	ш	400		
11	Еэвэн	Увс хүнс,өгөөж,чихэрлэг багатай, хугацаа	ш	500		
12	Боорцог	Увс хүнс-шар цаастай,өгөөж хугацаатай	ш	900		

13	Боорцог	Өгөөж	ш	200		
14	Боорцог	Өгөөж коворушк,хавчуургатай	ш	200		
15	Ургамлын тос	Дөрвөлжин савлагаатай корона,Олейна,	ш	60		
16	Үзэм	Орос,хятад хугацаатай, хадгалалт сайн	кг	41		
17	Каш	Орос славо, 1-кг савалгаатай	ш	30		
18	Шар будаа	Орос славо, 1-кг савалгаатай	ш	30		
19	Гурвалжин будаа	Орос бор цаастай 0,7-г савлагаатай	ш	50		
20	Талх	Загасан,хугацаатай,хадгалалт сайн	ш	500		
21	Төмс	Эх орны үйлдвэрийн	кг	1200		
22	Байцаа	Эх орны үйлдвэрийн	кг	50		
23	Манжин	Эх орны үйлдвэрийн	кг	300		
24	Лууван	Эх орны үйлдвэрийн	кг	350		
25	Чацаргана жүүс	Увс хүнс 0,5-г савлагаатай хугацаатай	ш	150		
26	Чацаргана	Эх орны ургацын	кг	50		
27	Сүү	Цэвэр малын	л	1000		
28	Цай	Гүрж савлагаатай,0,5-г	ш	6		
29	Цай	Орос шар цай	ш	6		
30	Варань	Орос,шар хайрцагтай 0,5-г олон жимст	ш	32		
31	Пүнтүүз	Шар цаастай	ш	100		
32	Давс	1-кг савлагаатай,иоджуулсан	ш	80		
33	Печень	Орос,16ш савлагаатай ногоон,шар цаастай	ш	380		
34	Печень	Цайны дугуй хэлбэртэй,орос	кг	80		
35	Сонгино	Эх орны үйлдвэрийн	кг	75		
36	Хүнсний овьёос	Орос,хугацаатай,хадгалалт сайн	ш	16		
37	Аарц	Малын	кг	100		
38	Айраг	Ингэний	л	500		
39	Хөөлт	Данболи,хугацаатай	ш	51		
40	Хөц будаа	Орос,хугацаатай, 0,5-г савлагаатай	ш	16		
41	Аньс	Эх орны үйлдвэрийн 0,5-кг савлагаатай	ш	25		
42	Чинжүү	Хугацаатай ,эх орны үйлдвэр,хадгалалт сайн,хугацаатай	кг	10		
43	Өндөг	Орос,хугацаатай,муудаагүй,стандарт хангасан	ш	250		
44	Ногоон цай	Орон нутгийн хөрсөнд ургасан,технологийн дагуу бэлтгэгдсэн	кг	5		
45	Загас	Орон нутгийн,муудаагүй,хадгалалт сайн	кг	50		
46	Зөв аарц	Эх орны үйлдвэр,хугацаатай,1-л савлагаатай	ш	180		
47	Тараг	Цэвэр малын сүүгээр хийсэн,хугацаатай	л	300		
48	Зөгийн бал	Орос 0,250-кг шилтэй,хугацаатай	ш	50		

49	Бор гоймон	Эх орны үйлдвэрийн алтан тарианы	ш	150		
50	Алим	Орос,муудаагүй	кг	25		
51	Чавга	Орос,хугацаатай	кг	10		
52	Үхрийн нүд	Эх орны үйлдвэрийн,хугацаатай,хадгалалт стандартын дагуу	кг	27		
53	Далайн байцаа	Чанарын шаардлага хангасан,хугацаатай,	ш	25		
54	Хүрэн манжин	Эх орны үйлдвэр	кг	50		
55	Сүү	Хугацаатай,эх орны үйлдвэр Өглөө" "Цэвэр" сүү	ш	97		
56	Молока	Орос,шахмал савлагаатай 0,3г савлагаатай,цэнхэр өнгийн цаастай	ш	16		
57	МОЛОКО	Орос,төмөр лааз савлагаатай	ш	16		
58	ГОймон	Орос,дун,3,5кг савлагаатай хугацаатай	кг	100		
59	Тараг	Эх орны үйлдвэр,хугацаатай,1,350г савлагаатай	л	160		
	Дүн					55.477.60 0

Тайлбар: 2020 оны батлагдсан төсөв нийт /63807200/ 2019-2020 оны хичээлийн жилд дотуур байранд 82 хүүхэд амьдарч байна. Энэ онд 1-9 р анги 33 долоо хоног хичээллэх ба 33х7хоног=231 өдөр болж байна. дотуур байрны нэг хүүхдийн хоногийн хоолны зардлын 3475 төгрөгөөр тооцов. Ерөнхий нөхцөл болон тавигдах шаардлагыг гэрээний тусгай нөхцөлд тусгаж өгөх болно.

1. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]